



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/103

Шивээговь сум

Боловсролын байгууллагын шаардлагатай
тоног төхөөрөмж хүлээж авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авч буй “Боловсролын байгууллагын шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах” ажлыг хүлээж авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

М.Гантуяа

(Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Д.Буяндэлгэр

(Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

Б.Алтансүх

(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Д.Баянбилэг

(Ерөнхий боловсролын сургуулийн нярав)

Нарийн бичгийн дарга:

Д.Баттуул

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авч буй “Боловсролын байгууллагын шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах” ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг комиссын дарга (М.Гантуяа)-д, өмч хөрөнгийг бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан

мэргэжилтэн (Д.Баттуул)-д, өмч хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, үр ашгийг дээшлүүлэн ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Д.Буяндэлгэр)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА *Ч.Сугармаа* Ч.СУГАРМАА

